МЭДЭЭ · 2022 оны 5-р сарын 9

ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГА "ХҮҮХДИЙН ДУУ ХООЛОЙ-2022" ЧУУЛГАНД ОРОЛЦОЖ, ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Чингэлтэй дүүргийн прокурорын газраас "ХҮҮХДИЙН ДУУ ХООЛОЙ-2022" нэгдсэн чуулганд оролцлоо.

Чуулганд ерөнхий боловсролын сургуулийн 200 гаруй сурагчид оролцож, "Хүүхдэд ээлтэй-Өрх гэр бүл", "Хүүхдэд ээлтэй-Орон нутаг", "Хүүхдэд ээлтэй-Боловсролын үйлчилгээ" зэрэг сэдвүүдийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулиудад салбар хэлэлцүүлгийг зохион байгуулж, гарсан санал зөвлөмжийг нэгдсэн чуулганы үеэр сурагчдад танилцуулсан ба "ШИЙТГЭЛ БОЛ ШИЙДЭЛ БИШ" сэдэвээр хүүхдийн дуу хоолойг сонсох, хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох, хүүхдийн хүмүүжлийн эерэг хандлагыг түгээх соёлын арга хэмжээг зохион байгууллаа.



Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2144